



2019 оны төсвийн төсөл дэх Уул уурхайн салбарын орлогын анализ

СУДЛААЧ А.БАТПҮРЭВ

2018 оны 10 дугаар сар

Танилцуулга

	2018Б	2019Т	Өсөлт
Төсвийн нийт орлого ба тусламж	7.86	11.06	40.7%
Нийт тэнцвэржүүлсэн орлого	7.23	9.67	33.7%
Уул уурхайн салбараас үүсэлтэй орлого	1.89	3.00	59.0%
Нийт орлогод эзлэх хувь	24%	27%	31.0%

Судалгааны зорилго

2019 оны Улсын төсөвт уул уурхайн салбараас төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг задлан шинжилснээр дараах 2 зорилгыг дэвшүүлэв. Үүнд;

- Эрдэс баялгийн бүтээгдэхүүнүүдийн үнийн төсөөлөл, зах зээлийн нөхцөл байдал буюу үйлддэрлэл экспортын хэмжээ, энэ оны гүйцэтгэлтэй харьцуулан үнэлж төсвийн орлогын төлөвлөгөө хэрэгжих боломжид дүгнэлт өгөх, учирч болох эрсдлийн талаар асуудал дэвшүүлэх
- Улсын нэгдсэн төсөвт уул уурхайн салбарын эзлэх байр суурь, үзүүлэх нөлөө, гүнзгийрэлтийг эдийн засаг, төсвийн стратеги, зорилтуудтай харьцуулж бодлогын хэрэгжилтэд үнэлэлт өгөх.

Ашигласан эх сурвалжууд

- 2019 оны Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөл, Засгийн газраас УИХ-д өргөн барьсан төсөл, 2018 оны 10 дугаар сар
- Өмнөх онуудын батлагдсан төсвийн мэдээллүүд, 2015-2018, <http://iltod.gov.mn/>
- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын үндэсний тайлангууд, 2013-2017 <https://e-reporting.eitimongolia.mn/>

Танилцуулга

Хязгаарлалт

Судалгаа нь цаг хугацаа, нөөцийн хувьд хязгаарлагдмал хүрээнд хийгдсэн тул төсвийн төслийн орлогын төлөвлөгөө боловсруулсан аргачлал, үүн дотроо эрдэс баялгийн салбарын үйлдвэрлэл ба төсвийн орлогын тооцоолол, загварчлалын үнэн зөв байдал, татвар, төлбөр, хураамжуудын хувь хэмжээ, хамрах хүрээний оновчтой байдал зэрэгт үнэлэлт өгөхгүй харин үйлдвэрлэлийн тоо хэмжээ, үнийн хандлагад үндэслэн дүгнэлт өгнө. Ингэхдээ эрдэс баялгийн олон улсын зах зээлийн бүрэн шинжилгээ хийж, экспортын гол бүтээгдэхүүнүүдийн үнийн алтернатив хувилбар санал болгохгүй хоёрдогч эх үүсвэрийн мэдээлэл, түүхэн хандлага, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн шалгууруудад үндэслэн таамаглал дэвшүүлнэ.

Гүйцэтгэсэн хугацаа

2018 оны 10 дугаар сарын 15–с 2018 оны 10 дугаар сарын 23.

Бүтэц

- (I) Уул уурхайн салбараас төсөвт төвлөрүүлэх орлогын хэрэгжих боломж
- (II) Уул уурхайн салбарын төсөвт үзүүлэх нөлөө ба, бодлогын уялдаа
- (III) Дүгнэлт гэсэн үндсэн гурван хэсгээс бүрдэнэ.

Гол нэр төрлийн эрдэс баялаг




4.1.2.“гол нэр төрлийн эрдэс баялаг” гэж тухайн жилийн нэгдсэн төсвийн орлогын гурав ба түүнээс дээш хувийг нь бүрдүүлж байгаа тухайн төрлийн эрдэс баялгийг (ойлгоно);

6.1.Төсөвт дараахь тусгай шаардлагууд нэгэн зэрэг хангагдсан байна:


6.1.1.нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх;

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль



Нүүрсний үнэ

Нүүрсний үнийн хандлага
Австралийн коксжих (\$/тн)




Хятадын хэрэглээ буурч байгаа, боомтуудад үлдэгдэл ихэссэнтэй холбоотойгоор 2019 онд нүүрсний үнэ энэ оны түвшнээс 20% хувиар буурах таамаглалыг эх сурвалж дэвшүүлж байна.

Төсвийн төсөлд ДБ-ны таамаглалаас бага зэрэг өндөр байгаа ч бусад байгууллагуудын дундаж таамаглалаас (\$110) бага бөгөөд төсвийн тусгай шаардлагад нийцэж байна.

Зэсийн үнэ

Зэсийн үнийн хандлага
(\$/тн)




- Хятадын эдийн засгийн өсөлт саарч бүтцийн шинэчлэл хийгдэж байгаагаас богино хугацаанд эрэлтэд сөргөөр нөлөөлнө.
- Цахилгаан хөдөлгүүртэй машины үйлдвэрлэл эрэлтийг нэмэгдүүлнэ.
- Урт хугацаандаа тогтвортой

Төсвийн төсөлд ДБ-ны таамаглалаас бага бөгөөд төсвийн тусгай шаардлагад нийцүүлж таамгаласан.

АЛТНЫ ҮНЭ

Алтны үнийн хандлага
(\$/унци)



Дэлхийн эдийн засгийн тогтворгүй байдал нэмэгдэхийн хэрээр алтны чангарч байна.

Сүүлийн 5 жилд үйлдвэрлэл өсөх хандлагатай байгаа ч алтны орлогын төсөвт үзүүлэх нөлөө буурч байна.

Монголбанкинд тушаах хэмжээ хангалттай нэмэгдэхгүй байгаа.

2018 оны орлогын төлөвлөгөө

	Орлогын төлөвлөгөө	Орлогын гүйцэтгэл	Зөрүү	Давсан орлогын хувь
I улирал	1,635,508.7	1,993,794.2	358,285.5	22%
II улирал	1,998,407.4	2,557,638.3	559,230.9	28%
III улирал	1,996,814.3	2,630,230.0	633,415.7	32%
Хуримтлагдсан дүн	5,630,730.4	7,181,662.5	1,550,932.1	25-28%

Эх сурвалж;

СЯ, Төсвийн хуваарь 2018.2

АМГТГ, Төсвийн орлого бүрдүүлэлт 2018.10

	Төсөв 2018
АМНАТ	806.4
ААНОАТ	390.1
Ногдол ашиг	47.8
Лицензийн төлбөр	37.0
Бусад	438.8
Нийт	1,720.1

2018 оны
хүлээгдэж
буй гүйцэтгэл
2.1 их наяд
төгрөг

2018 оны батлагдсан төсөвтэй харьцуулахад уул
уурхайн орлого 59% илүү, харин хүлээгдэж
байгаа гүйцэтгэлтэй харьцуулахад 39 орчим
хувиар илүү байхаар байна.


Үйлдвэрлэл

	Нэгж	2015	2016	2017	2018Т	2018ХБГ	2019Т
Нүүрс	сая тн	24.2	35.5	48.1	37.4	43.6	51 (42+9)
Зэсийн баяжмал	сая тн	1.33	1.44	1.31	1.36	1.43	1.4
Алт	тн	14.5	18.4	19.8	21	19.1	21
Төмрийн хүдэр	сая тн	4.27	4.93	7.69	7.5	6.84	NA
Газрын тос	сая баррель	8.76	8.24	7.62	8.1	6.4	8.2

Эх сурвалж;

- ЗГ, Төсөв 2018, iltod.gov.mn
- АМГТГ, Уул уурхайн салбарын статистик, 2018.8
- Монголбанк, Алтны статистик, 2018.9

Үйлдвэрлэлийн хэмжээний өсөлтийн хувь
(2018ХБГ-2019 төсөв)



Нүүрсний хэмжээ 2018 оны төсөвлөснөөс 36%-р нэмэгдэж байгаа хэдий ч хүлээгдэж байгаа гүйцэтгэлтэй харьцуулахад 18-20 хувиар илүү байхаар байна.

Газрын тосны энэ оны гүйцэтгэл төлөвлөснөөс бага байгаагаас ирэх оны төлөвлөгөө ихээхэн өсөлттэй мэт харагдаж байна.


Экспорт

	Нэгж	2015	2016	2017	2018Т	2018ХБГ	2019Т
Нүүрс	сая тн	14.47	25.81	33.4	28	36.4	42
Зэсийн баяжмал	сая тн	1.47	1.56	1.44	1.36	1.43	1.4
Төмрийн хүдэр	сая тн	5.06	6.08	6.25	7.5	6.84	NA
Газрын тос	сая баррель	8.13	8.01	7.51	8.1	6.4	8.2

Эх сурвалж;

- ЗГ, Төсөв 2018, iltod.gov.mn
- АМГТГ, Уул уурхайн салбарын статистик, 2018.8
- Монголбанк, Алтны статистик, 2018.9

Экспортын биет хэмжээний өсөлтийн хувь
(2018 ХБГ - 2018 төсөв)



Нүүрсний экспортын бие хэмжээ 2018 оны төсөвлөснөөс ойролцоогоор 50%, хүлээгдэж буй гүйцэтгэлээс 15% нэмэгдэхээр байгаа нь анхаарал татаж байна.

Хэдийгээр үйлдвэрлэлийн чадал энэ хэмжээнд хүрэх боломжтой харагдаж байгаа (өмнөх слайд) хэдий ч тээвэр, боомт зэрэг бусад хүчин чадал хүрэлцэх эсэх дээр дүгнэлт өгөх мэдээлэл хангалтгүй байна.

Хулгайгаар чухам хэдэн тонн нүүрс гарч ирсэн вэ?

Уул уурхайн орлогын төсөвт эзлэх хувь



Төсвийн уул уурхайн салбараас хамаарах хамаарал улам бүр гүнзгийрч байна.

Харьцуулахад Чили 15%


Олон улсын уул уурхай, металын зөвлөлийн Mining Contribution Index – р 16 дугаарт.

Table 1. MCI ranks and scores for the top 25 countries in 2018

2018 rank	Country	2018 score	2016 rank	Difference in ranks (2016 - 2018)
1	Suriname	96.43	47	+46
2	Congo, Dem. Rep.	96.40	1	-1
3	Guinea	94.28	31	+28
4	Burkina Faso	93.45	3	-1
5	Kyrgyz Republic	93.31	9	+4
6	Mali	93.22	33	+27
7	Sierra Leone	92.59	15	+8
8	Liberia	92.08	8	0
9	Ghana	90.94	14	+5
10	Uzbekistan	89.13	7	-3
11	Namibia	87.64	44	+33
12	Madagascar	87.14	4	-8
13	Botswana	86.13	5	-8
14	Armenia	84.93	20	+6
15	Tajikistan	84.90	10	-5
16	Mongolia	84.89	21	+5


Уул уурхайн орлогын бүтэц, хандлага

Гол бүтээгдэхүүн тус бүрээр орлогын урсгалын харьцаа
(тэрбум төгрөг)



- Ногдол ашиг 5 дахин (Эрдэнэт, Эрдэнэс ТТ)
- ААНОАТ +87%
- АМНАТ +57%
- Лицензийн төлбөр +16%


Орлогын урсгалуудын хэмжээ, өсөлт
(тб ₮)




- Нийт орлогын 42% АМНАТ-с
- ААНОАТ-с 24%
- Лицензийн төлбөрөөс 2%
- Ногдол ашиг 2-11%

Уул уурхайн орлогын хуваарилалт

Уул уурхайн орлогын хуваарилалт 2018



Уул уурхайн орлогын хуваарилалт 2019



Орон нутагт шинээр;


1. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 50% тухайн аймгийн орон нутгийн хөгжлийн санд
2. Газрын тосны тусгай зөвшөөрлийн төлбөрийн 30% тухайн орон нутгийн төсөвт
3. Олборлосон түүхий нүүрсэнд ногдуулах агаарын бохирдлын төлбөрийн 50% олборлолт явуулж байгаа орон нутгийн төсөвт

- Төсвийн тогтворжуулалтын санд 322 тэрбум
- Ирээдүйн өв санд 1,068.5 тэрбум –ХХС-ийн өр –Төсөвт шилжүүлэг =550 тэрбум

Салбаруудын үр өгөөж

	Лицензийн тоо	Төвлөрүүлэх орлого (тб ₮)	Нэг лицензэд ногдох орлого (сая ₮)
Зэс	32	1,304.0	40,334
Нүүрс	695	1,311.0	1,886
Алт	1296	83.0	64
Бусад	1209	302.0	250

Гол нэр төрлийн эрдэсүүдээр
лицензийн тооны харьцаа
(хайгуул+ашиглалт)



Эх сурвалж АМГТГ, 2018.7
Тооцоолол

- Нийт лицензийн тоо 3233
- Лиценз эзэмшгчийн тоо 1933
- Нэг эзэмшигчид дундажаар 1.7ш
- Хамгийн олон буюу 1296 лиценз алтны салбарт боловч хамгийн бага буюу 83 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж байгаа нь 1 лицензэд 64 сая төг.
- Харин хамгийн цөөн лицензтэй зэсийн салбар хамгийн үр өгөөж өндөртэй байна.
- Нүүрсний 1 лицензэд 1.8 төгрөгийн орлого

Дүгнэлт

- Гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн үнийг тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон тул зах зээлийн чиг хандлагатай нийцэж байна. Гагцхүү нүүрсний үнийн уналт прогнозоос илүү гүнзгийрвэл эрсдлийн хамгаалалт бага байхаар тулгаж тооцсон гэж үзэж болохоор байна.
- Уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэлийн биет хэмжээ зэсийн баяжмалаас бусад гол бүтээгдэхүүнүүд дээр ихээхэн өндөр өсөлттэй байгаа нь орлогын төлөвлөгөө хэрэгжих боломжид эргэлзээ үүсгэж байна. Нэн ялангуяа нүүрсний үйлдвэрлэл тооцсон хэмжээнд хүрлээ ч гэсэн тээвэрлэлт, боомтын нэвтрүүлэх чадвар зэрэг бусад хүчин зүйлийн улмаас төсөвт томоохон хэмжээний эрсдэл үүсч болзошгүй.
- Уул уурхайн орлогоос орон нутгийн төсөв хуваарилах хэмжээ нэмэгдэхийн зэрэгцээ Ирээдүйн өв санд хуримтлал үүсгэж эхлэх эерэг дүр зураг харагдаж байна.
- Орлогын урсгалууд дотор лицензийн төлбөр маш бага хувь эзэлж байгаа нь төлбөрийн хэмжээ, төлбөр тооцох аргачлал оновчтой эсэх асуултыг бий болгож байна. Мөн төрийн өмчийн ногдол ашиг маш тогтворгүй эрс тэс төлөвлөлттэй явж иржээ.
- Уул уурхайн дэд салбаруудын төсөвт үзүүлэх үр нөлөө харилцан эрс тэс байгаагийн дотор алтны салбарын үр ашигт байдал хамгийн муу харагдаж байна.
- Төсвийн уул уурхайн салбараас хамаарах хамаарал улам бүр нэмэгдэж байгаа нь эдийн засгийн тулгуурт байдлаар төрөлжүүлэн хөгжүүлэх бодлого хэрэгжихгүй байгааг илтгэж байна.